

"ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП" ХК-ИЙН ХАГАС ЖИЛИЙН

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ

Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.

Тайлагнах хугацаа	2023 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	"ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП" ХК, 9007001003, MSE:TNGR 95432111
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Хэвлэл мэдээлэл, контент үйлдвэрлэл
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	"ХҮЛЭГТХҮННУ АУДИТ" ХХК СЗХ-ны 2014 оны 06-р сарын 25-ны өдрийн 222-р тогтоол
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	6,000,000
Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга А.Удвал Хянасан: Санхүү эрхэлсэн захирал Д.Бат-Оюун Гүйцэтгэх захирал Г.Бат-Эрдэнэ

1.	<i>Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/</i>	
	Санхүүгийн байдлын үзүүлэлт	<u>Тайланг хавсаргав</u>
	Орлогын тайлан	<u>Тайланг хавсаргав</u>
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	<u>Тайланг хавсаргав</u>
	Мөнгөн гүйлгээний тайлан	<u>Тайланг хавсаргав</u>
1.1	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт	
	<u>Аудитын дүгнэлтийг хавсаргав</u>	
1.2	Аудитын тодорхойлолх захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/	
	<u>Аудитын тодорхойлох захидлыг хавсаргав.</u>	
2.	<i>Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл</i>	

2.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Санхүүгийн үзүүлэлтүүд																						
2.2.	Хөрвөр чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	<table border="1"> <tr> <td colspan="2" data-bbox="829 159 1542 174">Ашигт ажиллагаа</td> </tr> <tr> <td data-bbox="829 174 1349 243">Нийт хөрөнгийн өгөөж (ROA)</td> <td data-bbox="1349 174 1542 243">100.5%</td> </tr> <tr> <td data-bbox="829 243 1349 289">Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE)</td> <td data-bbox="1349 243 1542 289">100.6%</td> </tr> <tr> <td colspan="2" data-bbox="829 289 1542 325">Өөрчлөлтийн хувь /оны эхээс/</td> </tr> <tr> <td data-bbox="829 325 1349 371">Нийт активын өөрчлөлт</td> <td data-bbox="1349 325 1542 371">0.43%</td> </tr> <tr> <td data-bbox="829 371 1349 417">Зээлийн багцын өөрчлөлт</td> <td data-bbox="1349 371 1542 417">-100%</td> </tr> <tr> <td colspan="2" data-bbox="829 417 1542 453">Хөрөнгөд эзлэх хувь</td> </tr> <tr> <td data-bbox="829 453 1349 499">Өөрийн хөрөнгө/Нийт хөрөнгө</td> <td data-bbox="1349 453 1542 499">12.77%</td> </tr> <tr> <td data-bbox="829 499 1349 546">Өр төлбөр/Нийт хөрөнгө</td> <td data-bbox="1349 499 1542 546">-35.51%</td> </tr> <tr> <td colspan="2" data-bbox="829 546 1542 581">Хөрвөх чадварын харьцаа</td> </tr> <tr> <td data-bbox="829 581 1349 653">Хөрвөх чадварын хөрөнгө /Татан төвлөрүүлсэн хөрөнгө/</td> <td data-bbox="1349 581 1542 653">93.11%</td> </tr> </table>	Ашигт ажиллагаа		Нийт хөрөнгийн өгөөж (ROA)	100.5%	Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE)	100.6%	Өөрчлөлтийн хувь /оны эхээс/		Нийт активын өөрчлөлт	0.43%	Зээлийн багцын өөрчлөлт	-100%	Хөрөнгөд эзлэх хувь		Өөрийн хөрөнгө/Нийт хөрөнгө	12.77%	Өр төлбөр/Нийт хөрөнгө	-35.51%	Хөрвөх чадварын харьцаа		Хөрвөх чадварын хөрөнгө /Татан төвлөрүүлсэн хөрөнгө/	93.11%
Ашигт ажиллагаа																								
Нийт хөрөнгийн өгөөж (ROA)	100.5%																							
Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE)	100.6%																							
Өөрчлөлтийн хувь /оны эхээс/																								
Нийт активын өөрчлөлт	0.43%																							
Зээлийн багцын өөрчлөлт	-100%																							
Хөрөнгөд эзлэх хувь																								
Өөрийн хөрөнгө/Нийт хөрөнгө	12.77%																							
Өр төлбөр/Нийт хөрөнгө	-35.51%																							
Хөрвөх чадварын харьцаа																								
Хөрвөх чадварын хөрөнгө /Татан төвлөрүүлсэн хөрөнгө/	93.11%																							
2.3.	<p>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл</p>	<p><u>Тус мэдээллүүдийг хавсаргав.</u></p>																						
2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	Санхүү байдлын тайлангаас гадуурх бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй.																						
2.5.	Тайлант хугацаанд авсан зээлийн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;	2021, 2022 онд нийт “Ард актив” ХЗХ-с 1,6 тэрбум төгрөгийн зээл авч байсан бөгөөд тус зээлийг 2023 онд хаасан. Хараат компани болох Монгол телевизийн Голомт банкнаас авах зээлд зөвшөөрөл олгосон.																						
3.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/																							
	Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгээгүй.																							

4.	Цалин урамшууллын мэдээлэл
	2023 онд ТУЗ-ийн гишүүдэд цалин урамшуулал олгоогүй. Гүйцэтгэх удирдлагад 139 сая төгрөгийн цалин тооцсон. Гүйцэтгэх удирдлагын 2023 оны ажлын тайланг хэлэлцэн 82%-ийн гүйцэтгэлтэй ажилласан байна гэж дүгнэн урамшуулал олгох шийдвэрийг ТУЗ-аас гаргасан.
5.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл; Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл
	<p>2022 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын ХЭ-22/02 тоот тогтоолоор дараах гишүүдийг Төлөөлөн удирдах зөвлөлд томилсон. Үүнд: Ердийн гишүүд: Г.Уянга, Г.Бат-Эрдэнэ, Н.Мөнхнасан, Б.Золбоо, А.Ундрал, Ч.Батхүү Хараат бус гишүүд: Б.Наранзун, В.Ганзориг, Н.Цогт</p> <p>2023 оны 11 сарын 24-ний өдөр Н.Цогт гишүүнийг чөлөөлж, Б.Гантулга гишүүнийг түр томилсон.</p> <p>Компанийн эцсийн өмчлөгч: Гэр Интерьер Дизайн ХХК 36.4%</p> <p>Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид: Гэр Интерьер Дизайн ХХК 36.4% Ардын тэтгэврийн данс 11.8% Л.Чинбат 11.5% Г.Бат-Эрдэнэ 11.5% Ард санхүүгийн нэгдэл ХК 11% Н.Мөнхнасан 10%</p> <p>2022 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 22/07 тоот тогтоолоор ТУЗ-ийн даргаар Г.Уянгыг томилсон.</p> <p>2021 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 21/09 тоот тогтоолоор Г.Бат-Эрдэнийг Гүйцэтгэх захирлаар томилсон бөгөөд өөрчлөлт ороогүй.</p> <p>ТУЗ нь 2023 онд нийт 4 удаа биечлэн хуралдаж, эчнээ хэлбэрээр 15 удаа санал хураасан ба нийт 23 асуудал шийдвэрлэсэн. Мөн компанийн Аудитын хороо; Хөрөнгө оруулалт, санхүү эрсдэлийн хороо; Засаглал нэр дэвшүүлэх цалин урамшууллын хороод нийт 4 удаа хуралдсан.</p>
6.	Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл
	<u>Мэдээллийг хавсаргав.</u>
7.	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/
	<p>Компанийн эцсийн өмчлөгч: 36.4%-ийн хяналтын багц эзэмшигч “Гэр Интерьер Дизайн” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Уянга</p> <p>2023 оны 12 сарын 31-ний байдлаар компанийн нийт 6,000,000 ширхэг хувьцааг 1150 хувь хүн, аж ахуй нэгж эзэмшиж байна. 5 хувь буюу түүнээс дээш хувьцаа эзэмшигчид:</p> <ol style="list-style-type: none"> 1. Гэр Интерьер Дизайн ХХК 36.4%- 2,183,978ш 2. Ардын тэтгэврийн данс ХХК-11.8%- 706,402ш 3. Л.Чинбат 11.5%-692,175ш 4. Г.Бат-Эрдэнэ 11.5%-692,292ш 5. Ард санхүүгийн нэгдэл ХК 11%- 658,950ш 6. Н.Мөнхнасан 10%-600,000ш

8	<p>Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл</p>
	<p>2023 онд нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй. 2021 онд хаалттай хүрээнд 5,941,457 хувьцаа нэмж гаргах зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос 2021 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн №344 тоот тогтоолоор олгосон.</p>
9	<p>Ногдол ашгийн мэдээлэл</p>
	<p>Тэнгэрлиг медиа групп ХК-ийн санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааг цаашид хэвийн явуулахтай холбоотойгоор 2024 оны 2 дугаар сарын 19-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 24/02 тоот тогтоолоор ногдол ашиг хуваарилахгүй тухай шийдвэр гаргасан болно.</p>
10.	<p>Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл</p>
	<p>Охин компани Про медиа нетворк ХХК ба Анрид ХХК:</p> <p>ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНД ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙГУУЛЛАГААР ТОДРОВ TenGer TV нь 2023 онд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих чиглэлээр хэвлэл мэдээллийн салбарт бүтээлч санаачлагыг өрнүүлж, сайн туршлагаа түгээн дэлгэрүүлсэн тул “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдэг хэвлэл мэдээллийн байгууллага”-аар тодорлоо. Уг шагналыг Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлөөс гардуулжээ.</p> <p>ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ ХӨТӨЛБӨРИЙГ ДЭМЖИВ TenGer TV нь нийгмийн хариуцлагын хүрээнд “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг дэмжин, долоо хоног тутмын эфирээрээ “Хүнсний хувьсгал” нэвтрүүлгийг үнэ төлбөргүйгээр цацлаа.</p> <p>“ТЭРБУМ МОД” САНГИЙН ТЭТГЭЛГИЙГ ХҮРТЭВ TenGer TV нь тогтвортой хөгжлийн үзэл санааг түгээн дэлгэрүүлж, сайн туршлагаудыг хуваалцан хэрэгжүүлэгчдийг алдаршуулах зорилготой “Цэнхэр толбо” мэдээллийн хөтөлбөрийг нэвтрүүлж эхлэв. Энэ хөтөлбөр нь “Тэрбум Мод” сангаас байгаль орчны сайн санаачлагыг дэмжих тэтгэлэгт хөтөлбөрт хэвлэл мэдээллийн сангийн дэмжлэгийг хүртсэн юм.</p> <p>“АЛТАН ҮЗЭГ” НААДМЫН ИВЭЭН ТЭТГЭГЧЭЭР АЖИЛЛАВ Сэтгүүл зүйн чиглэлээр суралцаж буй оюутнуудын дунд явагддаг хамгийн том арга хэмжээ “Алтан үзэг 2023” наадамд TenGer TV, Unread Media компаниуд мэдээллийн ивээн тэтгэгчээр ажиллаж, “Мультимедиа контент”-ийн төрөлд шүүгчдийн багийг ахаллаа.</p> <p>ШИНЭ ОЮУТНУУДАД ЗОРИУЛСАН БОЛОВСРОЛЫН ЭВЕНТИЙГ ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛЛАА Unread Media 2018 оноос эхлэн ХААН Банктай хамтран шинэ оюутнуудын хамгийн том цугларалт тодотголтой “Rise” арга хэмжээг зохион байгуулсаар ирсэн. Энэ жилийн арга хэмжээнд TenGer TV мөн нэгдэж, 1000 гаруй оролцогчтойгоор амжилттай зохион байгууллаа.</p> <p>НИЙГМИЙГ ЭЭРЭГ ӨӨРЧЛӨЛТӨД УРИАЛСАН ХӨТӨЛБӨР, ЭВЕНТҮҮДИЙГ ДЭМЖИВ Unread Media компани нь нийгмийн ээрэг өөрчлөлтийг өртөөлж, залуусын оролцоог нэмэгдүүлэх чиглэлийн арга хэмжээ, төсөл хөтөлбөрүүдийг дэмждэг уламжлалтай. 2023 онд “Хүүхэд бүрд цэнхэр тэнгэр”, “Тогтвортой санхүүгийн долоо хоног”, YouthSpeak: залуусын дуу хоолой форум”, “ICT Expo 2023”, “Тогтвортой хөгжлийн төлөөх үндэсний чуулган”, “Улаанбаатар” олон улсын медиа урлагийн наадам”, “Tomyo Talk 2023” арга хэмжээнүүдийн медиа түншээр ажиллалаа.</p> <p>ХҮҮХДИЙГ ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛООС СЭРГИЙЛЭХ ҮЙЛСЭД ХУВЬ НЭМРЭЭ ОРУУЛЛАА Unread Media компани Toyota брэндтэй хамтран хүүхдийн зам тээврийн боловсролыг нэмэгдүүлэх зорилготой “Toyota Safetybook” төсөлд 2 дахь жилдээ хамтарлаа. Энэ ажлын хүрээнд замын хөдөлгөөний дүрмийг таниулах зорилготой комик номыг бүтээн нийт 5000 гаруй хүүхэд багачуудад түгээжээ.</p>

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХЭД ИДЭВХИЙЛЭН АНХААРАВ

Unread Media нийтлэлийн бодлогоороо дамжуулан уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой хөгжлийн төлөөх үзэл санааг түгээн дэлгэрүүлэх эрхэм зорилготой ажилладаг. Энэ зорилгын хүрээнд ХААН Банктай хамтран бэлтгэдэг 2 долоо хоног тутмын цахим товхимол “2030”-ыг тасралтгүй бэлтгэн хүргэж, байгаль орчны чиглэлийн сайн туршлагуудыг алдаршуулах “Тогтвортой хөгжил” буландаа нийт 50 гаруй нийтлэлийг бичсэн байна.

Хараат компани Монгол телевиз ХХК:

Шинэчилгээ нэвтрүүлэг нь соёл, зөв хандлага, нийтийн тээвэр, хамтын амьдрал, байгаль эрүүл орчин, ногоон байгууламж, цэвэр агаар, эмх цэгцтэй хот гэх мэт нийгмийн асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хэрхэн зөв замаар бага өртөгтэй шинэ технологи ашиглан хэрхэн шинэчилгээ хийхийг харуулсан. Нийт 20 дугаар буюу 90,000 секундын нэвтрүүлэг Моод брэндийн үүсгэн байгуулагч Болд-той хамтран бүтээсэн байна.

Ирээдүйн санхүүгийн салбарт шударга залуусыг бэлтгэх зорилгоор 2006 оноос эхлэн жил бүр идэвх зүтгэлтэй оюутнуудыг сонгон шалгаруулж, сургалтын төлбөрийн тэтгэлэг олгодог “Шударга ёсыг бадраах сан”-д оюутны нийгмийн амьдралыг дэмжих, сурах үйлсэд дэмжлэг болох зорилгоор 1 сая төгрөг олгосон.

Монгол Телевиз нь залуу хойч үеэ бэлдэн гаргах үйлсэд үнэ хувь нэмэр оруулдаг билээ. Энэ ажилын хүрэн 2023 онд Авьяаслаг монголчууд шоу нэвтрүүлгийн хүрээнд 6 сарын хугацаанд СУИС, РТС, МУИС- уудаас 28 зураглаач, дууны найруулагч, сэтгүүлч оюутан залуус, Чимгээ нэвтрүүлгийн багт СУИС, РТС-ийн 8 сэтгүүлч, Suits буюу олон улсын форматаар Монголд анх удаа бүтээсэн кинонд 6 туслах зураглаач оюутан, Шинэчилгээ нийгмийн асуудлыг хөндсөн нэвтрүүлгийн хамт олон МУБИС-ийн 2 сэтгүүлч, Терминал 1.0 чөлөөт ярилцалгын нэвтрүүлгэт МУИС-ийн 2 сэтгүүлч оюутан, Монгол ТВ нь 2023 ондоо нийт 46 оюутан залуусын хөгжил дэвшил, мэдлэг чадварт үнэтэй хувь нэмэр оруулан цалинтай дадлагажуулсан байна.

Хараат компани Ори Студиос ХХК:

2023 онд нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн томоохон ажлууд:

Уурын зуухнаас Ургах наран хороолол хүртэл дулаан болон цэвэр усны шугамыг өргөтгөсөн 2 тэрбум төгрөгийн төсвийн ажил хийж гүйцэтгэсэн.

Дулааны шугам өргөтгөл:

- 120 диаметртэй дулааны шугамыг 200 диаметр болгон өргөтгөсөн бөгөөд нийт өргөтгөсөн шугамын урт нь 253,5 метр.

Цэвэр усны шугам өргөтгөл:

- 80 диаметртэй цэвэр усны шугамыг 150 диаметртэй болгон өргөтгөсөн бөгөөд өргөтгөсөн шугамын урт нь 58,6 метр юм.

Энэхүү томоохон ажилын үр дүнд өмнө нь гарч байсан зарим асуудлууд болох халаалтгүй болж хөлдөх, улмаар уурын тогоонд гал гарах эрсдэлтэй нөхцөл үүсэхээс сэргийлж чадсан бөгөөд Ургах наран хорооллын 496 айлын 9 байрын халаалалтын систем сайжирч тухайн хорооллын байрнуудын үл хөдлөх хөрөнгийн үнэ өссөн зэрэг эерэг үр дүнтэй байна.

Онцгой бүтээлийг Ори-оос уриатай “Ори Медиа” ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг “Хэрэглэгчийн зөвлөх” албан тушаалд ажиллуулдаг.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг огноо:

Овог, нэр:

Албан тушаал “Тэнгэрлинг Медиа Групп” ХК-ийн
компанийн
Гүйцэтгэх захирал Г.Бат-Эрдэнэ

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)



Овог, нэр:

Албан тушаал: “.....” ХХК аудитын
Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр:

Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга А.Удвал

Гарын үсэг: